

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 5 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар хот

Г “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон Г  
сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах  
ажиллагааны журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Компанийн тухай хуулийн 58 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.1, 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам” -ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Тендер санал гаргах, дүгнэх тухай журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд сурталчилахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

**ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЗААВАЛ БОЛОН  
САЙН ДУРЫН ҮНДСЭН ДЭЭР ХУДАЛДАН АВАХ САНАЛ ГАРГАХ  
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмын зорилго нь хувьцаат компанийн /цаашид “компанийн” гэх/ хяналтын багц эзэмшигчээс дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй энгийн хувьцааг худалдан авах санал заавал гаргах болон бүртгэлтэй хувьцаат компанийн энгийн хувьцааг эзэмшихээр аливаа этгээдээс сайн дурын үндсэн дээр энгийн хувьцаа худалдан авах санал гаргах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

1.2.1. "худалдан авах санал гаргах" гэж тогтоосон журмын дагуу бүртгэлтэй хувьцаат компанийн энгийн хувьцааг бүхэлд нь, эсхүл тодорхой хувийг дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт худалдан авах саналын дуудлага гаргахыг;

1.2.2. "худалдан авах санал заавал гаргах" гэж Компанийн тухай хуулийн 58.1-д заасны дагуу компанийн хяналтын багц эзэмшигчээс дангаараа буюу нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчтэй хамтран бусад бүх хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй энгийн хувьцааг худалдан авах санал гаргахыг;

1.2.3. "худалдан авах санал сайн дурын үндсэн дээр гаргах" гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.2-т заасан худалдан авах санал гаргахыг;

1.2.4. "худалдан авах санал хэсэгчлэн гаргах" гэж нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигч бүрийн эзэмшиж буй хувьцаанаас хувь тэнцүүлэн хэсэгчлэн худалдан авахаар сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргахыг;

1.2.5. "худалдан авах санал гаргагч" гэж дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, энэ журмын дагуу заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргаж буй, эсхүл гаргахаар Хороонд өргөдөл ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийг;

1.2.6. "нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигч" гэж худалдан авах санал гаргагчтай Компанийн тухай хуулийн 97.1-д заасан холбоо бүхий этгээдийг;

1.2.7. "нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигч" гэж компанийн энгийн хувьцааг худалдан авахаар худалдан авах санал гаргасан этгээдтэй нэгдмэл сонирхолгүй бусад энгийн хувьцаа эзэмшигчийг;

1.2.8. "хяналтын багц" гэж Компанийн тухай хуулийн 57.1-д заасан хэмжээний энгийн хувьцааг;

1.2.9. "хяналтын багц эзэмшигч" гэж Компанийн тухай хуулийн 57.1-д заасан хэмжээний энгийн хувьцааг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчтэй хамтран худалдан авсан хувьцаа эзэмшигчийг;

1.2.10. “худалдан авах саналын мэдээлэл” гэж Хорооноос зөвшөөрсөн худалдан авах саналын нөхцөл, түүнтэй холбогдох бусад нийтэд хүргэх мэдээллийг.

## **Хоёр. Худалдан авах санал заавал гаргах**

2.1. Энэ журмын 2.2-т зааснаас бусад тохиолдолд компанийн хяналтын багцыг дангаараа болон нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигч хамтран худалдан авсан этгээд нь ажлын 60 хоногийн дотор нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй энгийн хувьцааг худалдан авахаар энэ журамд заасны дагуу худалдан авах саналыг заавал гаргах үүрэгтэй.

2.2. Дараах тохиолдолд худалдан авах санал заавал гаргахаас чөлөөлөгдөнө:

2.2.1. Нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааны хяналтын багцыг Хорооноос баталсан үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу хөрвүүлэн эзэмшсэн;

2.2.2. Нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааны хяналтын багцыг Хорооноос баталсан үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу андеррайтер андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд гэрээний үндсэн дээр эзэмшсэн;

2.2.3. Хяналтын багцыг хадгалж буй хадгаламжийн бичиг гаргасан кастодиан банк;

2.2.4. Хорооны хуралдаанаар тусгайлан шийдвэрлэсэн бусад тохиолдол.

2.3. Журмын 2.1-д заасан худалдан авах саналын баримт бичиг нь энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж байна гэж үзвэл Хорооноос худалдан авах санал гаргахыг зөвшөөрнө.

## **Гурав. Худалдан авах санал сайн дурын үндсэн дээр гаргах**

3.1. Нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн хувьцааг бүхэлд нь буюу хэсэгчлэн худалдан авахаар аливаа этгээд сайн дурын үндсэн дээр энэ журамд заасны дагуу худалдан авах санал гаргаж болно.

3.2. Худалдан авах санал сайн дурын үндсэн дээр хэсэгчлэн гаргасан тохиолдолд худалдан авах санал гаргагчийн нэмж эзэмшихээр тооцож байгаа хувьцаа нь компанийн хяналтын багцаас доош байна.

3.3. Энэ журмын 3.1-д заасан худалдан авах саналын баримт бичиг нь энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж байна гэж үзвэл Хорооноос худалдан авах санал гаргахыг зөвшөөрнө.

3.4. Хэсэгчлэн гаргах худалдан авах саналын хүчинтэй байх хугацаа дуусч, худалдан авах ажиллагаа хэрэгжсэний дараа худалдан авах санал гаргагч 12 сарын хугацаанд арилжаанаас бусад аливаа хэлбэрээр тухайн компанийн хувьцааг өмчлөлдөө нэмж авахыг хориглоно.

## **Дөрөв. Худалдан авах санал гаргах хүсэлт гаргах, зөвшөөрөх, зөвшөөрөхөөс татгалзах**

4.1. Худалдан авах санал гаргагч нь худалдан авах санал гаргах хүсэлт гаргахдаа зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлсөн байх бөгөөд Хороонд худалдан авах саналын баримт бичгийг ирүүлэхдээ төлсөн баримтыг хамт ирүүлнэ.

4.2. Ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, эсхүл Ажлын албанаас худалдан авах санал гаргахыг зөвшөөрөхөөс татгалзах шийдвэрийн төслийг Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр шийдвэрлэвэл тэр тухай худалдан авах санал гаргагчид бичгээр мэдэгдэн

Хорооны хуралдаанаар эцэслэн шийдвэрлэгдэхээс өмнө албан ёсны тайлбар гаргах боломжоор хангана.

4.3. Хэрэв шаардлагатай гэж үзвэл Хороо худалдан авах санал гаргагчаас нэмэлт мэдээлэл, баримт бичиг, албан ёсны тайлбар гаргуулан авах, тэдгээрийг холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажуулахыг шаардаж болно.

4.4. Худалдан авах санал гаргахаар Хороонд ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч ирүүлэх шаардлагатай баримт бичгийн бүрдэл хангагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

4.5. Хороо худалдан авах санал гаргахыг зөвшөөрөх эсэх талаар шийдвэр гаргахдаа худалдан авах саналын нөхцөл нь нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдэд ижил тэгш боломж олгосон эсэх, нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдийг худалдан авах саналтай нь холбоотой өөрсдийн эрхийн талаар мэдээлэл авах боломжоор хангаж чадах эсэхийг харгалзан үзнэ.

4.6. Хороо худалдан авах санал заавал гаргахыг зөвшөөрөхөөс татгалзсан тохиолдолд хяналтын багцад хүргэхгүй байх зорилгоор энгийн хувьцааны тодорхой хувийг нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдэд худалдахыг хяналтын багц эзэмшигчээс шаардаж болно.

4.7. Дараах тохиолдолд худалдан авах санал гаргах, худалдан авах саналын үндсэн дээр хувьцаа худалдан авахыг хориглож, зөвшөөрлийг хүчингүй болгоно:

4.7.1. Энэ журмаар тогтоосон болон Хорооноос баталсан худалдан авах саналын мэдээллийг нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдэд хүргээгүй, эсхүл тэдгээр баримт бичигтэй танилцах боломжоор хангаагүй;

4.7.2. Хорооноос зөвшөөрсөн худалдан авах саналын мэдээллийг Хорооны зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн;

4.7.3. Хуурамч баримт бичиг бүрдүүлж ирүүлсэн нь тогтоогдсон.

4.8. Худалдан авах санал гаргагч нь худалдан авах саналын мэдээлэлд өөрчлөлт оруулахаар Хороонд хүсэлт гаргаж болно. Ийнхүү хүсэлт гаргахын өмнө худалдан авах саналыг хүлээн авагч, уг үнэт цаасыг гаргагч, үнэт цаасыг бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллагатай уг асуудлаар урьдчилж зөвшилцсөн байна.

4.9. Энэ журмын 4.8-д заасан зорилгоор ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш Хороо 30 хоногийн дотор зохих шийдвэрийг гаргана.

4.10. Худалдан авах санал гаргагч нь Хорооны зөвшөөрөлгүйгээр худалдан авах саналыг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохыг хориглоно.

#### **Тав. Худалдан авах саналын мэдээлэл**

5.1. Худалдан авах саналын нөхцөл дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1. Доод хугацаа ажлын 60 хоног, дээд хугацаа 6 сар байх;

5.1.2. Хувьцаа худалдан авахаар санал болгож буй доод үнийг тухайн хувьцааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, худалдан авах санал гаргагч тухайн хувьцааг худалдан авсан дээд ханш хоёрын аль өндрөөр, тухайн хувьцааны нэрлэсэн үнээс доошгүй байхаар тогтоох;

5.1.3. Хувьцаа худалдан авах төлбөрийг зөвхөн мөнгөн хөрөнгөөр төлөх;

5.1.4. Нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдийг ижил тэгш нөхцлөөр хангасан байх, худалдан авах саналыг хүлээн авагчдаас сонголт хийх замаар зөвхөн заримаас нь хувьцаа худалдан авахгүй байх;

5.1.5. Худалдан авах саналын хүчинтэй хугацаанд эзэмшиж буй хувьцаагаа худалдахгүй байх, худалдан авах саналын бус нөхцлөөр хувьцаа худалдан авахгүй байх;

5.1.6. Худалдан авах саналын нөхцөл хангагдаагүй тохиолдолд худалдан авах саналыг хүчингүйд тооцох эсэхийг шийдвэрлэх;

5.1.7. Худалдан авах саналын дүнд компанийн хувьцааны 90 хувиас доошгүй энгийн хувьцааг худалдахаар худалдан авах санал хүлээн авагчдаас санал ирүүлсэн бол худалдан авах санал гаргагч нь үлдсэн нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдээс хувьцааг худалдан авахаар Хорооны зөвшөөрснөөр Хорооны тогтоосон нөхцөл шаардлага, хугацаанд дахин худалдан авах санал гаргах, ийнхүү гаргах үнэ нь өмнөх худалдан авах саналын үнээс багагүй байх;

5.1.8. Худалдан авах саналын дүнд арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шаардлага хангахаа больсон тохиолдолд бүртгэлээс хасах хүсэлтээ холбогдох байгууллагад хүргүүлэх.

5.2. Худалдан авах саналын хугацаа гэж нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдэд худалдан авах саналын нөхцөл, холбогдох бусад нийтэд хүргэх мэдээллийг хүргэж эхлэх мөчөөс худалдан авах саналын нөхцлөөр тогтоосон дуусгавар болох мөч хүртэлх хугацааг ойлгоно.

5.3. Сайн дурын үндсэн дээр гаргах худалдан авах саналд худалдан авах санал гаргагчийн, эсхүл түүнтэй гэрээ, хэлцэл байгуулсан этгээдийн нэг талын санаачилгаар худалдан авах саналыг хүчингүй болгох болон худалдан авах санал гаргагчийн, эсхүл түүнтэй гэрээ, хэлцэл байгуулсан этгээдээс шууд хамаарах болон хамаарахгүй үйл явдлаас шалтгаалан худалдан авах саналыг хүлээн авагчдын хувьцааг худалдан авахгүй байх аливаа нөхцөл тусгахыг хориглоно.

5.4. Хэсэгчлэн гаргах худалдан авах саналд энэ журмын 5.1-д зааснаас гадна нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигч бүрийн эзэмшиж буй хувьцааны хэдэн хувийг худалдаж авах талаар тухайлан тусгасан байна.

5.5. Хорооноос тухайлан өөрөөр тогтоосноос бусад тохиолдолд худалдан авах саналын нөхцөл нь энэ журмын 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан нөхцлийг тусгасан байх бөгөөд өөр нөхцөл тусгахыг хориглоно.

5.6. Бусад нийтэд хүргэх мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

5.6.1. Худалдан авах санал гаргагчийн нэр, компани бол Төлөөлөн удирдах гишүүд, гүйцэтгэх удирдлага, хяналтын багц эзэмшигчийн нэр, худалдан авах санал гаргаж буй компанид тэдгээр хяналтын багц эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо хэмжээ, хувь;

5.6.2. Худалдан авах санал гаргагчийн хувьцааг нь худалдан авах гэж буй компанид эзэмшиж байгаа хувьцааны тоо хэмжээ, хувь;

5.6.3. Худалдан авах санал гаргагч өөр компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол тэр тухай мэдээлэл;

5.6.4. Худалдан авах санал гаргах болсон шалтгаан, зорилго, үүний хүрээнд худалдан авах санал амжилттай болсон тохиолдолд компанийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах эсэх, хөрөнгийг худалдах, өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтцийн өөрчлөлт хийх зорилготой эсэх талаарх мэдээлэл;

5.6.5. Худалдан авах санал амжилттай болсон тохиолдолд компанийн ажилнуудын ажлын байрыг хадгалах эсэх;

5.6.6. Худалдан авах саналын дагуу хувьцаа худалдан авахад шаардагдах мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь хувьцаа худалдан авах захиалгыг биелүүлэхэд хүрэлцээтэй эсэх талаар гаргасан үнэт цаасны хадгаламжийн байгууллага, кастодиан банкны баталгаа;

5.6.7. Нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигч болон түүний мэргэжлийн зөвлөгчид худалдан авах саналыг хүлээн авах, эсхүл татгалзах шийдвэр гаргах дүгнэлт, шинжилгээ хийхэд шаардлагатай гэдэг нь илт байгаа бусад мэдээлэл.

5.7. Нийтэд хүргэх мэдээллийг Хороонд ирүүлэхдээ түүнийг нотлох баримт бичгийг хамт ирүүлнэ.

### **Зургаа. Худалдан авах саналын мэдээллийг хүргэх, мэдээлэх**

6.1. Худалдан авах санал гаргагч нь Хороонд худалдан авах санал гаргах хүсэлт гаргасан талаараа тухайн хувьцааг гаргасан компани болон уг хувьцааг бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллага, тухайн компанийн нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа худалдан авах санал зарлаагүй бусад этгээдэд ажлын 3 хоногийн дотор хүргэнэ.

6.2. Худалдан авах саналын мэдээллийг хүлээн авагчийн албан ёсны хаягаар хаяглан шуудангийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад шилжүүлснээр хүргэсэнд тооцно.

6.3. Хорооноос зөвшөөрсөн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор худалдан авах санал гаргагч нь Хорооноос зөвшөөрсөн худалдан авах саналын мэдээллийг компанид болон компанийг бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллага, компанийн нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа худалдан авах санал зарлаагүй бусад этгээдэд хүргэх ба бусад нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдэд нэг бүрчлэн хүргэж Хорооноос зөвшөөрсөн агуулга, хэлбэрээр эдгээр мэдээллийг олж авах боломжоор хангасан байна.

6.4. Худалдан авах санал гаргагч нь худалдан авах санал гаргасан тухай мэдээллийг худалдан авах санал хүчинтэй байх хугацаанд өдөр тутмын, орон нутагт тараагддаг 2-оос доошгүй хэвлэл болон орон даяар нэвтрүүлгээ түгээх эрх бүхий радио, телевизээр худалдан авах санал хүчинтэй байх хугацаанд 10-аас доошгүй удаа нийтлүүлнэ.

6.5. Энэ журмын 6.2-т зааснаас гадна нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчийг худалдан авах саналын мэдээллийг олж авах боломжоор хангах үүргийг Хороо, компанийг бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллага мөн адил хүлээх бөгөөд шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор энэ ажиллагааг өөрийн цахим хуудаст байршуулах хэлбэрээр гүйцэтгэнэ.

### **Долоо. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс худалдан авах саналтай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

7.1. Хувьцааг нь худалдан авахаар санал болгосон хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурал нь энэ талаар саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын олонхиор тусгайлан шийдвэр гаргаагүй бол хяналтын багцыг эзэмшихээр санал гаргасан этгээдэд хувь нийлүүлэгчдийн зүгээс хувьцаагаа худалдахад нь ямар нэг саад учруулж болохгүй.

7.2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь худалдан авах саналын талаарх худалдан авах санал гаргагчаас компанийн энгийн хувьцааг эзэмшиж буй бусад хувьцаа эзэмшигчдэд зориулан мэдээлэх компанийн байр суурийг илэрхийлсэн хариу мэдэгдлийг

Хороо худалдан авах саналыг зөвшөөрсөн шийдвэр гаргаснаас хойш ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

7.3. Энэ журмын 7.2-т заасан хариу мэдэгдэлд дараах мэдээллийг тусгасан байна:

7.3.1. компанийн үндсэн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх эсэх, хөрөнгийг худалдах, өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтцийн өөрчлөлт хийх зорилготой эсэх талаар худалдан авах санал гаргагчаас гаргасан мэдэгдлийн талаарх компанийн байр суурь;

7.3.2. худалдан авах санал гаргагчаас гаргасан аливаа мэдэгдэл, мэдээлэлд залруулга хийх;

7.3.3. худалдан авах санал амжилттай болсон тохиолдолд компанийн ажилтнуудын ажлын байрыг хадгалах эсэх талаар худалдан авах санал гаргагчаас гаргасан мэдэгдлийн талаарх компанийн байр суурь;

7.3.4. худалдан авах санал гаргасан нь үндэслэлтэй эсэх, үүний хүрээнд ашиг орлогын таамаглал нь үндэслэлтэй эсэх талаарх компанийн байр суурь;

7.3.5. Нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигч болон түүний мэргэжлийн зөвлөгчид худалдан авах саналыг хүлээн авах, эсхүл татгалзах шийдвэр гаргах дүгнэлт шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээлэл.

7.4. Хариу мэдэгдлийг Хороонд ирүүлэхдээ нотлох баримт бичгийг хамт ирүүлнэ.

7.5. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь энэ журмын 7.2-т заасан хариу мэдэгдлийг бэлтгэхдээ хараат бус аудитор томилж, түүнээс мэргэжлийн туслалцаа авсан байна.

7.6. Хороо журмын 7.2-т заасан мэдэгдлийг зөвшөөрөхийн өмнө түүнд оруулсан мэдээллийг өөрчлөхийг шаардаж болно.

7.7. Хороо журмын 7.2-т заасан хариу мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор нийтэд мэдээлэхийг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэнэ.

7.8. Хороо мэдэгдлийг нийтэд мэдээлэхийг зөвшөөрсний дараа компани нь Хорооноос баталсан агуулга хэлбэрээр нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдэд нэг бүрчлэн хүргэх бөгөөд эдгээр баримт бичгийг олж авах боломжоор хангасан байна.

7.9. Компани нь хариу мэдэгдлийг өдөр тутмын, орон нутагт тараагддаг 2-оос доошгүй хэвлэл болон орон даяар нэвтрүүлгээ түгээх эрх бүхий радио, телевизээр худалдан авах санал хүчинтэй байх хугацаанд 10-аас доошгүй удаа нийтлүүлнэ.

### **Найм. Худалдан авах санал хэрэгжих**

8.1. Худалдан авах саналын мэдээлэл нийтэд хүрсний дараа худалдан авах саналын дуудлагыг хүлээн авагч нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчийн саналыг арилжаа эрхлэх байгууллагад тухайн хувьцаа эзэмшигчийн харилцагч брокер, дилерийн компани нь бүртгүүлнэ.

8.2. Худалдан авах саналын дагуу хувьцаагаа худалдахаар өгсөн захиалгын дагуу бүртгэл хөтөлсөн брокер, дилерийн компани нь уг захиалгыг арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагад бүртгүүлж, санал хэрэгжүүлэх арилжааны нэг удаагийн хэлцэл хийгдэх хүртэл арилжаанд оруулахгүй байх түр тохиргоог хийлгэнэ.

8.3. Худалдан авах саналыг хүлээн авч худалдах захиалга өгсөн хувьцаа эзэмшигч хувьцаагаа тухайн саналаас бусад нөхцлөөр бусдад арилжих бол өмнө өгсөн захиалгаа цуцалсны дараа өөр бусдад арилжиж болно.

8.4. Санал амжилттай хэрэгжих болсон тохиолдолд худалдан авах саналын хугацаа дуусмагц, худалдан авах саналын дагуу хийгдэх хэлцлүүдийг нэгтгэн нэг удаагийн арилжаагаар гүйцэтгэнэ.

8.5. Худалдан авах саналын хугацаанд худалдан авах санал гаргагч нь саналд зааснаас өөр нөхцлөөр тухайн хувьцааг худалдан авахыг хориглоно.

### **Ес. Ашиг орлогын таамаглал, хөрөнгийн үнэлгээ**

9.1. Худалдан авах санал гаргагч нь худалдан авах саналтай холбоотойгоор нийтэд хүргэх мэдээлэлдээ, эсхүл компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хариу мэдэгдэлдээ ашиг орлогын таамаглал, хөрөнгийн үнэлгээг тусгасан тохиолдолд түүнийг тусгах болсон үндэслэл, ашиг орлогын таамаглалын талаар хараат бус аудиторын дүгнэлт, хөрөнгийн үнэлгээний талаар хараат бус хөрөнгийн үнэлгээчний дүгнэлтийг заавал оруулна.

9.2. Хараат бус аудитор гэдэгт бүртгэлтэй хувьцаат компани, худалдан авах санал гаргагч, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдээс хараат бус, тэдгээртэй компанийн ашиг орлогын таамаглал бэлтгэх, түүнд дүгнэлт хийхээс өөр бусад асуудлаар аливаа гэрээ хэлцэл хийгээгүй, Хорооноос хүлээн зөвшөөрсөн аудитор, аудитын байгууллагыг ойлгоно.

9.3. Хараат бус хөрөнгийн үнэлгээчин гэдэгт бүртгэлтэй хувьцаат компани, худалдан авах санал гаргагч, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдээс хараат бус, тэдгээртэй компанийн хөрөнгийн үнэлгээ хийх, түүнд дүгнэлт хийхээс өөр асуудлаар аливаа гэрээ хэлцэл хийгээгүй, Хорооноос хүлээн зөвшөөрсөн үнэлгээчнийг ойлгоно.

### **Арав. Худал, төөрөгдүүлсэн мэдээлэл тараахыг хориглох**

10.1. Аливаа этгээдээс худалдан авах саналтай холбоотой худал, төөрөгдүүлсэн, материаллаг хохирол учруулахуйц мэдээллийг компанийн нийт хувьцаа эзэмшигч, тэдгээрийн мэргэжлийн зөвлөхөд өгөх, эсхүл олж авах боломжоор хангахыг хориглоно.

10.2. Аливаа этгээдээс компанийн хувьцаа эзэмшигч, тэдгээрийн мэргэжлийн зөвлөхийг төөрөгдүүлэх зорилгоор худалдан авах санал зарлахтай холбоотой үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

### **Арван нэг. Худалдан авах санал гаргаагүйгээс үүсэх үр дагавар**

11.1. Компанийн хяналтын багцыг худалдан авч заавал худалдан авах санал гаргах үүрэг хүлээсэн этгээдийн уг үүргийн талаарх мэдээллийг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага хяналтын багц худалдан авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Хороонд мэдэгдэх болон олон нийтэд өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх үүрэгтэй.

11.2. Худалдан авах санал заавал гаргах этгээд нь уг саналыг хуульд заасан хугацаанд гаргаагүй бол уг этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрх эдлэхгүй.



11.3. Саналын эрхгүй болсон хувьцааны талаарх мэдээллийг Хороо өөрийн цахим хуудсаар дамжуулан ажлын 15 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

### **Арван хоёр. Хариуцлага**

12.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.

----- оОо -----